

**НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАН ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024.12.02

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2024 оны жилийн эцсийн хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1.	2.	3.	4.
Нэг. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлөөр хангах чиглэлээр			
1.1	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул гарсан ажлын байранд байгууллага дотроосоо болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас чадахуйн зарчмыг баримтлан томилох арга хэмжээг зохион байгуулах	Тус байгууллагын батлагдсан орон тоо-48, жилийн эцсийн байдлаар ажиллаж буй албан хаагч-37 байна. Сул орон тоо-11 түүнээс төрийн албан хаагчийн чадахуйн зарчмыг баримтлан байгууллага дотроосоо томилогдсон албан хаагч-2, холбогдох төрийн бусад байгууллагаас шилжүүлэн томилсон-1, тусгай шалгалтаар сонгогдож томилогдсон-3 нийт 6 албан хаагч байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалын "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай журам" –ын хүрээнд бусад байгууллагаас шилжүүлэн ажиллуулсан-1, бусад байгууллагад шилжүүлсэн-5, нийт 6 албан хаагчийг хуульд нийцүүлэн сэлгэн ажиллуулах, шилжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	100%
1.2	Төрийн захиргааны албан хаагчийн төрийн алба хаасан хугацааг тодорхойлж, нэмэгдэл олгох, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр олгох ахиулах, ажлыг зохион байгуулах	Байгууллагын төрийн захиргааны шаардлага хангасан албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/369 дүгээр захирамж "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай", Газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/56 захирамжаар нийт 7 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлж, ХНЦС-д шивж оруулсан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Зэрэг дэвийн нэмэгдэлд- 28,584,500 төгрөгийг, албан хаасан жилийн нэмэгдэлд-23,810,400 төгрөгийг олгосон байна.	100%

		Нийт жилийн эцсийн байдлаар 52,394,900 төгрөгийг олгосон байна.	
1.3	Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласан албан хаагчийг нөхөн амруулах	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай" 09 дүгээр тогтоолын хүрээнд 2024.03 дугаар 09, 10-ний өдрүүдэд мал тууж хашаалах ажилд нийт 35 албан хаагч оролцсон.Тус өдрүүдэд ажилласан албан хаагч нарыг нөхөн амрах хуваарийн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн амраасан. 2024 оны жилийн эцсийн байдлаар 7 дугаар сард Баяр наадмын өдрүүдээр ажилласан 4, 8 дугаар сард илүү цагаар ажилласан 7 албан хаагчид мөн 9,10,11 саруудад нийт 37 албан хаагчийн илүү цагийн нэмэгдэлд 11,905,400 төгрөгийг олгосон байна.	100%
1.4	Албан хаагчдын улсад болон төрд ажилласан жилийг нэг бүрчлэн тулган шалгаж, түүнд үндэслэн ээлжийн амралт олгох хугацааг тогтоож, хуваарийг батлуулж, ээлжийн амралтыг олгох, амралтын тооцоо хийх ажлыг зохион байгуулах	2024 оны ээлжийн амралтын саналыг нийт 36 албан хаагчдаас авч Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлүүдийг үндэслэн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан байна.Тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд жилийн эцсийн байдлаар 36 албан хаагчийн ээлжийн амралтын хуудсыг бүрэн олгож, 51,181,600 төгрөгийг зарцуулсан байна.	100%
1.5	Албан хаагчдад нөхөх төлбөр, тэтгэвэр тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тухай бүр шийдвэрлэх	-Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор хоолны мөнгийг жилийн эцсийн байдлаар 2 удаа нэмэгдүүлсэн байна.Тус газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.2-т тусгаж, газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар албан хаагч бүрт сар тутам хоолны төсөв 9000 төгрөг байсныг 13,000 төгрөг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар тогтоолыг үндэслэн Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн А/42 тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлыг 34,000, нийтийн тээврийн унааны зардлыг 1000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон байна. Жилийн эцсийн байдлаар унааны зардалд-5,447,500, хоолны мөнгөнд-168,349,000, нийт 173,796,500 төгрөгийг олгосон байна.	100%

		Тус газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар "Цагаан сар" билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан байгууллагын 3 өндөр настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж 300,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон. "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10 дугаар зүйлийн 10.7 дахь заалт Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 0-16 насны 86 хүүхэд багачуудад нийт (4,370,000) төгрөгийн бэлгийг гардуулан өгсөн. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтад заасан дагуу 3 албан хаагчид тус бүр 300,000 төгрөг, нийт 900,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.	
1.6	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгох асуудлыг шийдвэрлэх	Байгууллагын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 22 ажилтан, албан хаагч чөлөө хүссэн өргөдөл газрын даргад гаргасан бөгөөд 20 албан хаагчдад газрын даргын тушаалаар тус тус "Цалинтай" чөлөөг олгосон байна. Мөн албан хаагчдыг ар гэр, үр хүүхдүүдтэйгээ цагаа өнгөрүүлэхэд нь зориулж 0-16 хүртэлх насны хүүхдийнх нь төрсөн өдрөөр нь байгууллагаас 1 өдрийн цалинтай чөлөөг олгож байхаар "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-даа шинээр тусган оруулж, 15 албан хаагчид чөлөө олгосон байна. Ар гэрт нь хүнд гачигдал тохиолдсон гэх шалтгааны улмаас чөлөө хүссэн 3 хаагчид мөн цалинтай чөлөөг олгосон байна.	100%
1.7	Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр улирал бүр урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дугаар тушаалаар албан хаагчдыг ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэн, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" батлах тухай 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тушаал 2024 оны 05 дугаар 29-ний А/38 дугаар тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг" үнэлгээ хийж, газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн Б/67 дугаар тушаалаар төрийн захиргааны болон үйлчилгээний нийт 29 ажилтан, албан хаагчдыг үнэлж 40,466,000 төгрөгийн урамшууллыг олгосон байна.	100%

Хоёр. Ажиллах нөхцөл бололцоог хангах чиглэлээр			
2.1	Албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай байгаа техник хэрэгсэл, бичиг хэргийн хангамжийн судалгааг авч тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах	Албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай байгаа техник хэрэгсэл, бичиг хэргийн хангамжийн судалгааг албан хаагч нараас авч шийдвэрлэхээр ажилласан. Тус судалгааны хүрээнд НЗДТГ-аас иж бүрэн компьютер-6, принтер-3 олгосон байна. Мөн газрын даргын 2024 оны А/80, А/93 дугаар тушаалаар таблет-1%, залгуур, усны аппарат, печд гэх мэт техник хэрэгслийг авахад 7,080,000 төгрөгийг зарцуулсан байна. Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/53 дугаар тушаалаар 1,200,000 төгрөгийн зардлыг гаргаж, нийт 34 албан хаагчдын компьютерын вирусын программын лиценз, хэрэглээний программуудын лиценз, засвар үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулсан. Албан хаагчдын бичиг хэргийн зардалд 4,300,000 төгрөгийг олгосон.	100%
2.2	Албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийн давхардал, ажлын хэт ачааллыг оновчтой хуваарилах ажлыг зохион байгуулах	Тус байгууллагад батлагдсан орон тоо-48 түүнээс 37 албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна. Ажлын хэт ачааллыг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Чиг үүрэг тодорхойлох тухай" 22 дугаар тогтоолоор чиг үүргийг шинжилгээг хийсэн. Тус шинжилгээнд төрийн захиргааны 18 албан хаагч хамрагдсан бөгөөд шинээр 2 хэлтэс 23 албан хаагчийг бий болгох шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна.	100%
Гурав. Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр			
3.1	3.1 Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, түүнийг хэрэгжүүлэх хөрөнгийг төсөвт тусгаж шийдвэрлэх	Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөг 4 заалт 5 ажил арга хэмжээ хийхээр нийт төсөвт 1,900,000 төгрөгийг тусгасан байна. Жилийн эцсийн байдлаар дараах сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд: -"Байгууллагын үнэ цэнэтэй ажилтан, зан төлөвт суурилсан багийн ажиллагаа, байгууллагын соёл" сэдэвт сургалтыг 23 албан хаагчдад; -"Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох хууль, тогтоомжийг танилцуулах" сургалтыг 22 албан хаагчдад, -"Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтыг 32 албан хаагчдад;	100%

		-2024 оны 05 дугаар сарын 27, 28-ны өдөр "Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-ын 2.1.3. "хуулиар тогтоосон улсын байцаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж чадах мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадвартай байх" мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын нийт 4 хяналтын улсын байцаагчдыг; - Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 1 албан хаагч; - Ашигт малтмал, газрын тосны газраас зохион байгуулсан Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпорацийн Монгол дахь төлөөлөгчийн газар Комир Эм ЖИ Эл ХХК-тай хамтран газрын тосны бүтээгдэхүүн болон нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх мэргэжилтэнүүдэд зориулсан онол, практик хосолсон нийт 5 хоногийн сургалтад 2 албан хаагчийг; - Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 40 цагийн чиглүүлэх багц сургалтад 1 албан хаагчийг; - "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт, шинжилгээ үнэлгээний арга зүй сэдэвт сургалтанд нийт 8 албан хаагчийг; - ХНХТ-с сар бүр зохион байгуулдаг төлөвлөгөөт сургалтад нийт 58 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 120 гаруй албан хаагчдыг; Нийт давхардсан тоогоор 67 удаагийн сургалтад 37 албан хаагчийг хамруулсан байна.	
3.2	3.2 Бие даан болон хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах болон хэлний сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдыг дэмжиж, мэдлэг мэргэшлээ, дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангах	Бие даан хувиараа мэргэжил эзэмшиж буй албан хаагч-5 байна. Албан хаагчдад мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд нь ажлын цагийн хуваарийн уян хатан болгож, цалинтай чөлөөг тухай бүрт нь олгосон байна.	100%
Дөрөв. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр			
4.1	4.1 Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрт нь эмчилгээ, сувилгаа	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэх зорилгоор ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны А/86 дугаар тушаалаар байгуулж, Сөүл эмнэлэгтэй хамтран /ажилчдын багц шинжилгээ/ ходоодны дуран, хавдарын маркер, зүрх судас, эхо гэх мэт нийт 18 төрлийн	50%

	хийлгэх, эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх	шинжилгээнд хамруулсан. Тус үзлэгт газрын даргын 2024 оны А/87 дугаар тушаалаар 37 албан хаагчийг хамруулж 18,500,000 төгрөгийг зарцуулсан байна.	
4.2	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангаж холбогдох зардлыг шийдвэрлэх	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн 5 дах өдөр 19 00 цагаас спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөг зэргээр хичээллэх нөхцөл боломжоор хангасан байна. "Улаанбаатар марафон-2024" зохион байгуулагдаж, 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр "Авто машингүй" өдөр байгууллага, хамт олноороо тус өдөрт оролцож, 5км-ын ойрын зайн гүйлтийн тэмцээнд оролцохын зэрэгцээ авто машины хөдөлгөөнгүй үеийн хэмжилтийг Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтсийн 2 мэргэжилтэн хэмжиж ажилласан болно.	100%
Тав Албан хаагчдын гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр			
5.1	Шинээр гэр бүл болж байгаа болон залуу гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Тайлант хугацаанд албан хаагчдаас 1 албан хаагч шинээр хүүхэдтэй болсон тул Хөдөлмөрийн дотоод журмын 12.4 заасан чөлөө олгосон байна.	100%
5.2	Албан хаагчдын аль гэр бүлийн нэг гишүүн нь тусгай арчилгаа шаарддаг, өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй бол тусламж дэмжлэг үзүүлэх	Тайлант хугацаанд тус заалттай холбоотойгоор албан хаагчдаас өргөдөл ирээгүй болно.	100%
Зургаа. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад хамруулна.			
6.2	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ХНХТ-ийн мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалт Эрхэлсэн болон ахлах түшмэлийн зэрэг олгох; Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх;	Хагас жилийн байдлаар ХНХТ-өөс зохион байгуулдаг "Стресс менежмент", Excel программ, "Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэглээ", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" гэх мэт 58 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 120 гаруй албан хамрагдсан байна. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 1 албан хаагчийг, эрхэлсэн болон ахлах түшмэлийн сургалтад хамрагдах 2 албан хаагчийн мэдээллийг ХНМС-д бүртгэлжүүлсэн байна.	100%
6.3	Архив, бичиг хэргийн мэргэшүүлэх сургалтад хамруулах; А-3 сургалт Холбогдох байгууллагуудын сургалт	Архив бичиг хэргийн мэргэшүүлэх сургалтад бичиг хэргийн эрхлэгч Б.Гандаваа хамрагдсан. Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 1 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан байна.	100%

Долоо. Гадаад сургалт		
7.1	Гадаад, сургалт семинарт албан хаагчдыг хамруулах	-2024.05.13-20-ны өдрүүдэд Сөүл хотод зохион байгуулагдсан Монголын хот байгуулалтын мэргэжилтэнд зориулсан чадавхыг бэхжүүлэх сургалтад тус байгууллагаас Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Бат-Оюун, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Угтахбаяр нар хамрагдаж сертификат авсан. - 2024.10.20-27-ны өдрүүдэд Сөүл хот, Кёнсанбүг муж дахь Андог, Поханг зэрэг хотуудад нарны панель буюу сэргээгдэх эрчим хүчийг ашиглан цахилгаан эрчих хүчээ шийдэж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын туршлагатай танилцах томилолтоор Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Бат-Оюун, барилгын дулаан алдагдал, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Г.Ганчимэг нар оролцсон. -2024.09.20-30-ны өдрүүдэд Бүгд найрамдах Унгар улсын Будапешт хотын Сегедийн их сургуультай хамтран гэр хорооллын айл өрхийн ахуйн зуухнаас гарч буй утааг шүүх шүүлтүүрийн үйлдвэртэй танилцах, харилцан туршлага солилцох цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцох, судалгааны ажилд байгууллагаас газрын дарга Г.Даваажаргал, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Бат-Оюун, Агаарын чанарын хэмжилт зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн У.Жаргалбаатар, агентлаг хариуцсан ерөнхий нягтлан М.Мөнхтулга нар явсан бөгөөд томилолтын зардалд 29,500,000 төгрөгийг зарцуулсан байна. - 2024.09.08-15-ны өдрүүдэд Тайвань улс, Тапэй хотод Өмнөд ба Зүүн өмнөд Азийн орнуудын агаарын бохирдлыг бууруулах стратеги, олон улсын туршлага солилцох уулзалтад газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Даваажаргал оролцсон.
Нийт дундаж оноо: 7 ажил, 17 арга хэмжээ		100%

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.АРИУНТУНГАЛАГ

БИЕЛЭЛТ ТАЙЛАГНАСАН:
ЗСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Н.НЯМДУЛАМ